

МОНГОЛ УЛСЫН ХҮНИЙ ЭРХИЙН
ҮНДЭСНИЙ КОМИССЫН ГИШҮҮН

Ж.ДАШДОРЖ

**Төв аймгийн Борнуур, Замаар сумдад ашигт малтмалын
үйл ажиллагааны улмаас ард иргэдийн эрүүл аюулгүй орчинд
амьдрах эрх зөрчигдөж буй байдлыг судлан танилцах ажлын удирдамж**

2008.01.10

Улаанбаатар хот

Энэхүү судалгааны зорилго нь ашигт малтмалын хайгуул олборлолтын улмаас иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрх зөрчигдөж буй байдал, түүнд нөлөөлөх хүчин зүйлсийг судлаж, зөрчигдсөн эрхийг сэргээх, байгаль орчныг хамгаалуулахад чиглэгдсэн санал боловсруулахад оршино.

Нэг. Дээрх зорилгыг хангахын тулд дараах зорилтуудад хүрнэ:

1. Нутгийн иргэдийн эрх зөрчигдөж буй нөхцөл байдал, шалтгааныг тогтоох;
2. Ашигт малтмалын хайгуул, олборлолтын байгаль орчинд ээлтэй байдал, эерэг, сөрөг үр дагаварыг үнэлэх;
3. Олон нийтийн зөрчигдсөн эрхийг сэргээх, байгаль орчны хамгаалах механизмуудын үр нөлөөг дээшлүүлэх.,
4. Орон нутгийн иргэдийн эрх ашгаа хамгаалах мэдлэг чадварыг дээшлүүлэхэд нөлөөлөх;

Хоёр. Хэсэгчилсэн судалгааг хийхтэй холбогдуулан бэлтгэл ажлын талаар

1. Хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхийг хангахтай холбоотой стандартуудыг судлах;
2. Заамар суманд уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа компаниудын талаар мэдээлэл авах;
3. Мэдээлэл авах асуулгын маягт боловсруулах;

Гурав. Судалгаа явуулах газрууд, хугацаа, судалгааны арга хэлбэр

1. Заамар суманд 1 дүгээр сарын 20-нд очиж, 1 дүгээр сарын 21-ний өдөр 09-16 цагт сумын төвд ажиллаж, 16-17.30 цагт сумын төрийн болон төрийн бус байгууллагуудтай уулзалт зохион байгуулна. 17.30-19.30 цагт иргэдтэй уулзаж, эрүүл аюулгүй орчинд амьдрах, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрх, эрх ашгийнхаа төлөө тэмцэж, хамгаалах талаар яриа хийнэ;
2. 1 дүгээр сарын 22-нд Тосон Заамар дахь Өгөөмөр тосгон, сумын 3 дугаар багийн нутагт уул уурхайн чиглэлээр ажиллаж буй компаниудын баримт бичигтэй танилцаж, үйл ажиллагаа явагдсан газруудаар явах; Шаардлагатай бол энэ багийн болон бусад багийн иргэдтэй уулзалт хийнэ
3. 1 дүгээр сарын 23-нд ажиллагааны дүнгээ сумын удирдлагад судалгааны дүнг мэдээллэх,
4. 1 дүгээр сарын 24-нд Борнуур сум орж, 25-нд сумын төвд ажиллана. Мөн ашигт малтмалын үйл ажиллагаа явагдаж буй хөдөөгийн зарим газруудаар

явж танилцаж, иргэдтэй уулзана. 17.00 цагт сумын төрийн болон төрийн бус байгууллагуудын төлөөлөгчид, иргэдтэй уулзаж, хүний эрхийн талаархи тэдний мэдлэгийг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

Дөрөв. Судлах тогтоох үйл ажиллагааны чиглэл

Олон нийтийн эрх ашгийн төлөө тэмцэж, ард иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхийг хангаж, учирч буй бэрхшээл, түүнийг даван туулах талаар хийж буй ажлыг доорх байгууллага, албан тушаалтнуудаас танилцаж судална.

1. Сумын иргэдийн хурал тэргүүлэгчдээс:

- 1). Байгаль орчныг хамгаалах олон нийтийн эрх ашиг зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх талаар авсан арга хэмжээ.,
- 2). Олон нийтийг энэ ажилд оролцуулсан байдал үр дүн.,
- 3). Орон нутгийн тусгай хамгаалалтанд хэдэн “га” газар авсан.,

2. Сум, багийн засаг даргаас:

- 1). Газар болон ус ашиглах гэрээ хичнээн уул уурхайн чиглэлийн компанитай байгуулсан гэрээг дүгнэсэн байдал.,
- 2). Хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхийг хангах талаар авсан арга хэмжээ.,
- 3). Газрын хэвлийг ашиглах болон хайгуул олборлолтын үйл ажиллагаанд тавих хяналтыг хэрхэн яаж хэрэгжүүлдэг (ГХТХуулийн 52 дугаар зүйл).,
- 4). Тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбайг зориулалтаар ашиглуулах, зөрчил гаргавал таслан зогсоох (АМТХуулийн 12.1.1., 12.1.2).,
- 5). Тусгай хамгаалалт, тусгай хэрэгцээнд хичнээн “га” газар хэдэн удаа авсан.,
- 6). Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, хүн амын эрүүл мэндийг хамгаалах болон орон нутгийн төсөвт ямар компани хичнээн төгрөг төвлөрүүлсэн эсэх.,
- 7). АМТХуулийн 38, 39 дүгээр зүйлд заасан арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байдал.,
- 8). Нөхөн сэргээлэлтийн ажлыг бүрэн хийгээгүй уурхайн олборлолтын тухайн жилийн ажлыг эхлүүлэхгүй байх арга хэмжээ хэдэн компаний газар дээр авсан.,
- 9). Олон нийтийн хяналт тавих үүрэг бүхий төлөөлөгчдийг иргэд дундаасаа сонгон шалгаруулж тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагаанд хяналт тавихад сумаас хэрхэн чиглүүлж буй.,
- 10). Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдуулсан дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх асуудлаар уурхайн захиргаатай гэрээ байгуулсан, энэ талаар олон нийтийн хэлэлцүүлэг явуулсан байдал (АМТХуулийн 42 дугаар зүйл).,

3. Сумын засаг даргаас болон уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй компани дээр судлан танилцах зүйлүүд

- 1). Ашигт малтмалын хайгуул болон олборлолт явуулсан нийт талбай “га”-аар, үүнээс нөхөн сэргээлт хийгдээгүй хичнээн “га” байгаа, энэ нь хөдөөгийн хэчнээн малчин өрхийн малын бэлчээр, хадлангийн талбай, өвөлжөө, хаваржаа, намаржаа, зуслангийн талбай хамаарагдаж буй, үүнээс хэдэн “га”-ийн ой мод, бут, сөөг сүйтгэгдсэн болохыг холбогдох байгууллагаар тогтоолгож авах.,
- 2). Дээрх хайгуул, олборлолт явагдсан газарт булаг шанд байсан эсэх, гол горхины голдирол дотор олборлолт хийсэн эсэх, голын голдиролыг өөрчилсөн эсэх, ус нь бохирдсон, ширгэсэн гол горхи бий эсэхийг тогтоолгох.,

- 3). Эдгээр хайгуул, олборлолт явуулсан газарт тусгай хамгаалалттай газар нутаг хамрагдсан эсэх, уг зөвшөөрөл хуулийн дагуу олгогдсон эсэхийг тогтоох, тусгай зөвшөөрлийн гэрчилгээ бусад хуулбарыг үзэх.,
- 4). Байгаль орчны нөлөөлөх байдлын ерөнхий болон нарийвчилсан үнэлгээг тус тус хийлгэнэ. Нарийвчилсан үнэлгээг эрх авсан аж ахуй нэгж гүйцэтгэх бөгөөд эхэнүү нарийвчилсан үнэлгээний тайланд тусгавал зохих 10 төрлийн зүйлийг бүрэн тусгасан байдлыг тулган шалгаж үзэх.,
- 5). Төсөл хэрэгжүүлэгч буюу тухайн уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй компани нь байгаль орчинд нөлөөлөх, байдлын үнэлгээний тухай хуулийн 6 дугаар зүйлд зааснаар байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөртэй байх бөгөөд түүний төлөвлөлт, хэрэгжилтийн тайланг үзэх.,
- 6). Дээрх нарийвчилсан үнэлгээний тайлангийн дагуу ерөнхий үнэлгээ хийсэн байгууллага нарийвчилсан үнэлгээний шинжилгээг мэргэжлийн шинжээчээр хийлгэнэ. Энэ шинжээчийн дүгнэлтийг үндэслэн тухайн төсөл хэрэгжих газрын нутгийн иргэдээс авсан саналыг харгалзан Байгаль Орчны Яам уг төслийг хэрэгжүүлэхийг зөвшөөрсөн баримтыг авч үзэх;
- 7). Дээрх хуулийн 8 дугаар зүйл зааснаар энэхүү нарийвчилсан үнэлгээний дагуу төсөл хэрэгжүүлж буй аж ахуй нэгж, байгууллагын үйл ажиллагааны улмаас хүний эрүүл мэнд, байгаль орчинд хохирол учруулж байгаа болон учруулсан бол БОЯ хянан магадлагаа хийх ажлын хэсгийг томилон ажиллуулна. Энэ талаар хянан магадлагаа хийсэн эсэх.,
- 8). Тусгай зөвшөөрөл авснаас хойш 30 хоногийн дотор байгаль орчны хяналтын алба болон тухайн сум, дүүргийн засаг даргатай зөвшилцөн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө боловсруулж, төлөвлөгөөндөө байгаа орчны бохирдлыг зөвшөөрөгдсөн хэмжээнээс хэтрүүлэхгүй байх, эвдэгдсэн газрыг булах, тэгшлэх, ургамалжуулах, уурхайн ажиллагааг байгаль орчинд хохирол багатай явуулах, агаар мандал болон усны бохирдолт, хүн, амьтан, ургамалд үзүүлэх сөрөг нөлөөллөөс сэргийлэх арга хэмжээг тусгах, хортой болон хор хөнөөл учруулж болзошгүй бодис, материалыг хадгалах, хяналт тавих, гадаргын болон гүний усыг хамгаалах, ашиглах, хуримтлуулах, уурхайн хаягдлын далан барих, уурхайн талбайн аюулгүй байдлыг хангах зэрэг асуудлыг тусган хэрэгжүүлж, байгаль орчинд учирсан сөрөг нөлөөллийг тухай бүр бүртгэж, энэ төлөвлөгөөний биелэлт болон тайланг жил бүр БОЯ, аймаг, сум, дүүргийн засаг дарга, мэргэжлийн хяналтын албанд хүргэж байх үүрэгтэй. Иймд энэ талаарх жил бүрийн тайланг авч үзэх.,
- 9). Байгаль орчныг хамгаалах талаар хүлээсэн үүргээ биелүүлэх баталгаа болгож, хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч сум, дүүргийн засаг даргын нээсэн тусгай дансанд, ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч БОЯ-аас нээсэн тусгай дансанд байгаль орчныг хамгаалах арга хэмжээнд шаардагдах тухайн жилийн зардлын 50 хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгийг тус тус шилжүүлнэ. Энэ үүргээ хэрхэн биелүүлж байгаа дүнг, жил жилээр 2 газраас тодруулан асуух.,
- 10). Тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй байгуулсан хөрөнгө оруулалтын гэрээ, ашигт малтмалын ордыг ашиглах ашиглалтын өмнөх гэрээ, “энэ гэрээг хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч, төрийн захиргааны байгууллагын хооронд байгуулна” холбогдох хууль тогтоомжийн дагуу байгуулсан газар ба ус ашиглах гэрээ, тусгай зөвшөөрөл эзэмшигч нь байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх, асуудлаар нутгийн захиргааны байгууллагатай байгуулсан гэрээг тус тус авч үзэх ба гэрээг дүгнэсэн байдлыг анхаарах.,

Тав. Хэсэгчилсэн судалгааны явцад болон эцсийн хийх зүйл

1. Энэхүү судалгааны явцад хүний эрхийг зөрчиж хохироосон асуудлын талаар дүгнэлт хийж холбогдох газарт Комиссын гишүүний шаардлага, зөвлөмж явуулах;
2. Дээр дурдсан хүний эрхийг хангах талаар хийсэн ажлын ололттой сайн арга ажиллагаа, үр дүнг судлан сурвалжлага хийлгэж% нийтийн хүртэл болгох, олон

- нийтийн эрх ашгийг зөрчиж хохироосон асуудлыг нийтэд дохио, санамж болгох зорилгоор сурталчлах;
3. Судалгааны дүнгийн талаар хүний эрх , эрх чөлөөний төлөв байдлын 2008 оны илтгэлд тусгуулах;

ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИСС

UIN.MN
СУДАЛГААНЫ САН

Илтгэх хуудас

2008.01.30

Улаанбаатар хот

Ашигт малмалын үйл ажиллагааны улмаас ард иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах эрх зөрчигдөж буй байдлыг судлан танилцсан дүнгийн талаар

Монгол улсын хүний эрхийн үндэсний комиссын төслийн үндэсний зөвлөх Г.Далайжамц, Комиссын референт Б.Долгион, Монгол телевизийн сэтгүүлч Ш.Мөнхцэцэг, зураглаач Д.Энхтөр нар энэ сарын 20-25-ны өдрүүдэд төв аймгийн Заамар сум, мөн сумын 3-р баг, Жаргалант, Борнуур сумдуудад иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрх хэрхэн хэрэгжиж буй талаарх танилцах судалгааг хийлээ. Эдгээр бүс нутгуудад түүний дотор заамар суманд уул уурхайн салбар эрчимтэй хөгжсөн бөгөөд энэ сумдын зарим нутагт химийн хорт бодис хэрэглэсэн, хэрэглэх гэж байгаа зэрэг нь ихээхэн анхаарал татсан юм. Заамар сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн дарга Д.Болормаа, Засаг дарга Д.Раах, Байгаль орчны хяналтын улсын байцаагч Н.Гантөмөр, Л.Гансүх нараас болон зарим компанийн захирал, инженер, геологич, уурхайн дарга нартаа уулзаж, энэхүү судалгаа явуулсаны гадна байгаль хамгаалагч Н.Пүрэвдагва, Н.Цэдэн, Ч.Мөнхбаяр нартай хамт явж, 20 гаруй уурхайн эдэлбэр газруудаар биечлэн явж үзлээ.

Тус сумын ерөнхий төлөв байдал, нийтийн эрх ашигт хамааралтай зарим асуултын талаар товч танилцсан нь:

Заамар сум нь 5814 хүн амтай, 1636 өрхтэй, 98 мянган толгой малтай буюу хонин толгойд шилжүүлснээр 112856 малтай юм байна. Сумын иргэдийн төлөөлөгчдийн хурал, засаг даргын зүгээс сумаа хөгжүүлэх, хүн ардынхаа эрүүл аюулгүй орчинд амьдрах, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхийг хангахын тулд зохион байгуулалтын талаар авсан арга хэмжээний заримаас дурьдвал Сумын ИТХ-аараа байгаль орчныг хамгаалах асуудал болон сумын хэмжээнд тулгамдсан зарим асуудлыг авч хэлэлцэж байсны дотор сумын байгаль орчны талаар баримтлах бодлого, хүнс хөдөө аж ахуйн болон нийгмийн эрүүл мэнд, соёл, боловсролын талаар баримтлах бодлогын хэд хэдэн чухал баримт бичгийг батлуулан мөрдөж байгаа юм байна.

Сумын усан сан бүхий газар 1762 га талбай буюу нийт нутгийн дөнгөж 0.63 хувь, ой мод 6797 га-д нийт нутгийн дөнгөж 2.41 хувьд ойн сан бүхий газар тус тус эзэлдэг. Гэтэл тус сумын нутагт гар аргаар алт олборлогч /нинжа/ 8-10 орчим мянган хүн байсныг хоёр жилийн өмнө цагдаагийн хүчээр тэднийг хөөж гаргасан байна. Тэдгээр хүмүүс тэндхийн модыг нь түлшинд хэрэглэж модны нөөцийг багасган алтны илэрц бүхий газар болгоныг ухаж алт олборлоод ухсан нүхээ булахгүй орхин олон нүх гаргасан нь хүн, мал унаж, гэмтэх, зарим үед мал үхэх зэргээр аюултай орчин, нөхцөл бүрдүүлсэн байна.

Энэ нутагт 1990-ээд оны эхээр 39 зүйлийн ан амьтан, 140 төрөл зүйлийн шувуу, 16 зүйл загас жараахай, бах, мэлхий, 5-6 мянга орчим халиун буга байсан бол хулгайн анчдын халдлагад өртөж буга, согоо бараг үгүй болсон, тэрчлэн алтны олон уурхайн үйл ажиллагааны улмаас ан амьтан шувууд дөрвөж, цөөрч зарим нь үгүй болсон, мөн 40 орчим гол, горхи, булаг шанд рашаан, нуур цөөрөм байснаас 10 гаруй нь ширгэж, нилээд хэсгийнх нь ундарга нь багассан гэж дүгнэдэг юм байна. Иймээс сумын ИТХ-аас өмнөх гаргасан шийдвэрээ оролцуулан 2007 оны 3 дугаар сард нийт 213185.7 га газар нутгийг орон нутгийн тусгай хамгаалатанд авах шийдвэр гаргажээ. Энэ нь нийт нутгийн 75.8 хувийг эзэлж байна.

Энэ сумын нутагт анх Хайлаастын алтны уурхай нэртэй ТӨҮТ 1992-1997 онд ажиллаж, нөхөн сэргээлт хийгээгүй орхисныг одоогийн ажиллаж буй алтны зарим уурхайнууд дээр нь олборлолт явуулжээ. Тус сумын нутагт урьд нь 40 гаруй аж ахуйн нэгж, байгууллагууд алтны хайгуул, олборлолтын үйл ажиллагаа явуулж байснаас одоо

ашиглалтын 16, хайгуулын 2 компани ажиллаж байгаа гэв. Ер нь нийт 126 хайгуул, ашиглалтын лиценз олгогдсоны 80 гаруй нь ашиглалтынх бөгөөд алтны шороон ордны нөөц 60 тонн, үүнээс 58 тонныг олборлосон гэсэн тооцоотой байдаг юм байна.

Дээрхи компаниуд нь жилдээ 20-иод сая шоо метр хөрс хуулж, нэг сая гаруй шоо метр элс угааж, 4 сая шоо метр ус хэрэглэдэг. Одоогийн байдлаар 2500 орчим га талбай уулын малталданд өртсөнөөс 66 орчим хувьд нь нөхөн сэргээлт хийжээ.

Сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлын хувьд ТББ болон олон нийтийн оролцоонд тулгуурлан үйл ажиллагаагаа явуулдаг сайн тал байна. “Тосон заамар туул” хөдөлгөөнтэй хамтарч олон нийтийн эрх ашгийг зөрчиж буй зарим илрэлтэй тэмцэж, олон нийтийн анхаарлыг хандуулдаг байна.

Сумын засаг дарга, түүний тамгын газар нь “Тосон заамар сан” бий болгон түүндээ орон нутагт ажиллаж буй уул уурхайн компаниудаас хандив, тусламж авч сум, орноо хөгжүүлэхэд зориулсан сургуулийн дотуур байрны их засвар, хоёр давхар цэцэрлэгийн барилга бариулах, оёдлын жижиг үйлдвэрийн барилга зэрэг нийгэм, соёлын арга хэмжээнд зориулахын зэрэгцээ ажлын байр нэмэгдүүлэх, зам засуулах, малгүй өрхийг малжуулах арга хэмжээ авч байгаа юм байна. Тухайлбал: Сумын засаг даргын тамгын газар аж ахуйн нэгжүүдтэй 5 зүйл, 16 заалт бүхий гэрээг Заамар сумын засаг даргын зүгээс ААН-үүдтэй “Ашигт малтмалын тухай хууль”-ийн 42 дугаар зүйлийн 1 дэх заалтад “Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх асуудлаар нутгийн захиргааны байгууллагатай гэрээ байгуулж ажиллана” гэсэн заалтын дагуу нийт аж ахуйн нэгжүүдтэй гэрээ байгуулан ажилласан байна. Эдгээр аж ахуйн нэгжүүдээр 44 айл өрхийг малжуулах төсөлд хамруулж, цэцэрлэг, сургуульд засвар хийсэн зэрэг ажлуудыг хийлгэсэн байна. 2008 онд 88 айлыг малжуулах төсөлд хамруулахаар болоод байна.

Алтан Дорнод Монгол ХХК-тай 2007.01.01-2007.12.31 хүртэл хамтран ажиллах гэрээг байгуулсан бөгөөд гэрээний биелэлтийг энэ улиралд дүгнэнэ. Гэрээнд сумын дэд бүтцийг хөгжүүлэхэд анхаарах зорилгоор 60 сая төгрөг сумын нээсэн дансанд байршуулж, сумын засаг даргын тамгын газрын хэрэгцээнд Land Cruiser 100 машин хандивласан байна. Мөн мобикомын сүлжээг 2007 оны 10 сард оруулсан байна. Зөвхөн 2007 онд л гэхэд аймаг, орон нутгийн төсөвт усны төлбөрт 412 сая төгрөг, газрын төлбөрт 103 сая төгрөг тус тус төвлөрүүлсэн байна. Сумын Засаг даргын тамгын газар дээр дурьдсанчлан 3 янзын гэрээ байгуулсан боловч компаниудын удирдлага хот руу явсан учир гэрээгээ дүгнээгүй байна.

Тус сум нь 281.7 мянган км² талбайтай, үүнээс 90 мянгад нь буюу нийт газар нутгийн 3/1-д нь хайгуулийн буюу ашиглалтын лицензтэй. Орон нутгийн зүгээс 205 мянган га газрыг орон нутгийнхаа тусгай хамгаалалтанд авсан байдаг байна. Урьд жилүүдэд уул уурхайн чиглэлээр 20 гаруй аж ахуй нэгж байгууллагдай ажиллагаа явуулж байжээ. Үүнд:

1. Алтан Дорнод Монгол ХХК
2. Шижир алт ХК
3. Монполимет ХХК
4. Дацан трейд ХХК
5. Их алт ХХК
6. Аварга тосон ХХК
7. Уянган ХХК
8. Тод Ундарга ХХК
9. Санчиринвест ХХК
10. Хүслэмж ХХК
11. Монжап ХХК

УМАН
СУДАЛГААНЫ САН

12. Авдарбаян ХХК
13. АШБ ХХК
14. Бат алт төв ХХК
15. Зэрэгцээ ХХК
16. Илгуан ХХК
17. Оргил Мөнх ХХК
18. Тэмүүлэл ХХК
19. Т энд Ч ХХК
20. Эрэл ХХК

Эдгээр аж ахуйн нэгжүүд нь бүгд заамар сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг бөгөөд ашигт малтмалын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1.8-д "Хайгуулийн лиценз эзэмшигч нь байгаль орчныг хамгаалах талаар хүлээсэн үүргээ биелүүлэхийн баталгаа болгон холбогдох сум /дүүрэг/-ийн засаг даргын нээсэн тусгай дансанд байгаль орчныг хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах жилийн төсвийн 50 хувьтай тэнцэх мөнгөн хөрөнгийг оруулна. Лиценз эзэмшигч нь байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөг бүрэн хэрэгжүүлсний дараа барьцааны хөрөнгийг буцааж авна" гэсэн заалт үндсэндээ хэрэгжиж байгаа боловч уурхайн компаниуд маш бага хэмжээний мөнгө төлөвлөдөг байна.

Заамар суманд үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүд нь нөхөн сэргээлтийг дээрхи хуульд заасны дагуу гүйцэтгэхгүй байна. Одоо заамар суман дахь алтны ордуудын нөхөн сэргээлтийн байдлыг авч үзье.

- Алтан Дорнод Монгол ХХК-ийн хувьд Ар наймган /103.8 га/, Баянгол /523.6 га/, Хайлаастай /488 га/, Туулын баруун дэнж /64 га/, Туулын дэнж /402 га/ гэсэн газруудад ашиглалтын лицензтэй ба нийт лицензний талбай нь 1581.4 га байна. Хөндөгдсөн нийт талбай нь 1157.1 га, үүнээс 612.4 га талбайд нөхөн сэргээлтийг хийсэн байна. Туул голоос ус татан нэг драг нь ажилладаг.

- Монполимет ХХК нь Дэнж орд /455.4 га/, Тосонгийн гольдрол /523.6 га/ гэсэн газруудад олборлолт явуулдаг. Эвдэгдсэн нийт талбай нь 359.3 га, үүнээс 340.2 га-д нөхөн сэргээлтийг хийсэн байна. Үүнээс биологийн нөхөн сэргээлтийг 60.6 га-д хийжээ. 184 А ашиглалтын лицензтэй, 1996 оноос хойш үйл ажиллагаа явуулж байгаа. Зуны улиралд дунджаар 250-300 хүн ажилладаг. Туул голоос ус татан хиймэл нуур үүсгэсэн, түүн дээр 2 драг нь ажилладаг.

Монполимет ХХК-ийн Тосонгийн гольдролын шороон ордын нөхөн сэргээлтийн ажлын гүйцэтгэл			
Он	Олборлосон талбай	Биологийн	Техникийн
2003	17.4 га	0	9 га
2004	28.1 га	0	16.1 га
2005	58.1 га	0	33.1 га
2006	57.2 га	21.5 га	51.6 га
2007	50.1 га	39.3 га	54 га

д/д	Он	Олборлосон талбай /га/	Биологийн нөхөн сэргээлт /га/	Техникийн нөхөн сэргээлт /га/
1.	1996-1999	59.34		23.75
2.	2000	16.23		16.23
3.	2001	8.4	1	10
4.	2002	14.8		9.8

5.	2003	12	4	34
6.	2004	20	6	20
7.	2005	21	6	21
8.	2006	8.78	27	8.22
9.	2007		39.7	7.5

- Шижир алт ХХК нь Туулын гольдролд 718 га 175А лицензийн дугаар бүхий ашиглалтын талбайтай. 1995 оноос үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд хоёр драгтай. Драг нь туул голын гольдрилыг өөрчилж түүн дээр нь ажилладаг. Компаний нийт хувьцааны Монголросцветмет 51 хувь, Эрдэнэт концерн 24 хувь, Орос цветмет 23 хувийг нь эзэмшдэг. Нийт 413 ажилтантай, 2007 онд 379 хүнтэйгээр ажилласан байна. Хөндөгдсөн нийт талбай нь 529.5 га, үүнээс 267 га-д нөхөн сэргээлтийг хийжээ. Биологийн нөхөн сэргээлтийг 34 га-д нь хийсэн байна. 3 бульдозертой нөхөн сэргээлтийн хэсгийг байгуулсан байна.

- Дацан трейд ХХК нь Туул гол /282 га/-д 66/2А лицензийн дугаар бүхий ашиглалтын талбайтай. 2003 оноос хойш үйл ажиллагаа явуулж байна. Хөндөгдсөн нийт талбай нь 74.8 га бөгөөд үүнээс 58.6 га-д нөхөн сэргээлтийг хийжээ. Биологийн нөхөн сэргээлтийг 5 га-д хийсэн байна.

- Их алт ХХК урд дэлэн гэдэг газар 118А лицензийн дугаар бүхий 192 га талбайд олборлолт явуулдаг. 1997 оноос хойш ажиллаж эхэлсэн бөгөөд ашигласан нийт талбай нь 62.1 га, үүнээс 51 га-д нөхөн сэргээлтийг хийсэн байна.

- Аварга тосон ХХК нь Бага хайлааст 1998 оноос хойш ажиллаж байгаа 254 га газар болон Ар наймганы дээд хэсэгт 2006 оноос хойш ажиллаж буй 332А лицензийн дугаар бүхий 145 га талбайд ашиглалт явуулж байна. Хөндөгдсөн нийт талбай нь 5 га. Нөхөн сэргээлт хийгээгүй. Орон нутгийн удирдлага Аварга тосон ХХК-ийн үйл ажиллагаанд шүүмжлэлтэй ханддаг. Учир нь уг компани нь "Т энд Ч" ХХК нэрээрээ үйл ажиллагаа явуулж байгаад нөхөн сэргээлт огт хийлгүйгээр шинэ компани байгуулан түүндээ "Аварга тосон" гэсэн нэр өгч дахин ашиглалт явуулж эхэлсэн бөгөөд удалгүй Оргил Мөнх ХХК-д энэ газраа түрээслүүлсэн байна.

- Уянган ХХК нь Баянголын дэнжид 2005 оноос хойш 9495А лицензийн дугаар бүхий 87 га газарт олборлолт явуулж эхэлсэн байна. Хөндөгдсөн нийт талбай нь 91 га бөгөөд 42 га-д нь техникийн нөхөн сэргээлтийг хийжээ.

- Тод Ундарга ХХК 217 А лиценз бүхий 69 га талбайд 2004 оноос хойш үйл ажиллагаа явуулж байгаа. Эвдэгдсэн нийт талбай нь 75 га ба 43.4 га-д нь техникийн нөхөн сэргээлтийг хийжээ. Голын гольдролд лаг хийж бохир ус оруулдаг, олборлолтыг сорчилж явуулдаг гэсэн дүгнэлтийг орон нутгийн зүгээс хийсэн байна.

- Санчиринвест ХХК-ийн ашиглалтын нийт талбай нь 34 га бөгөөд 34 га-д ашиглалт явуулж дууссан. Нөхөн сэргээсэн нийт талбай нь 20 га байна. Нөөц нь дуусч 2005.02.05-нд лиценз цуцлагдсан боловч одоо хүртэл нөхөн сэргээлт бүрэн хийхгүй олборлолт явуулж байгаа бөгөөд лиценз нь хүчин төгөлдөр байхдаа хатуу цэгээсээ 200-300 метр хэтэрч олборлолт хийсэн байна.

- Хүслэмж ХХК тосонгийн дэнжид 10347А лицензийн дугаар бүхий 37 га талбайд ашиглалт явуулж байгаа бөгөөд хөндөгдсөн нийт талбай нь 9 га. Нөхөн сэргээлт хийгдээгүй байна.

- Монжап ХХК нь тосонгийн голд 2004 оноос хойш 60 га газарт ашиглалт явуулж байгаа. Нийт 5 га эвдэгдсэн бөгөөд нөхөн сэргээлт хийгээгүй байна.

- Авдарбаян ХХК нь салтгар улаан шивэр гэдэг газар 4910А лицензийн дугаар бүхий 16.6 га газар олборлолт явуулдаг. 1997 оноос хойш үйл ажиллагаа явуулж байгаа. Эвдэгдсэн нийт талбай нь 8 га бөгөөд 3.5 га-д нь нөхөн сэргээлт хийсэн байна.

- АШБ ХХК нь заамар сумын төвөөс 9 км-ийн зайд Баржин хэмээх нутгийн тусгай хамгаалалттай, нутгийнхны шүтдэг ууланд хайгуулийн лицензтэй үндсэн орд юм.

Хятадын хөрөнгө оруулалттай. Нутгийнхан лицензийг хүчингүй болгуулахаар бүх шатны шүүхээр заргалдсан боловч амжилт олж чадаагүй. Одоо хайгуулийн лицензтэй хэдий ч нинжа нар ухаж байсан, олборлолт явуулдаггүй гэх баталгаа байхгүй. Нийт 172 га талбайтай. 3 га газар хөндөгдөөд байгаа. Уулын энгэрийг хоёр хэсэг газарт нүхлэн /нүхний өргөн 180-190 см, өндөр 180-200 см хэмжээтэй/ нэг нь 500 гаруй метр ухаад нүхний амыг тагалсан, нөгөө нүх нь 100 гаруй метр ухсан, эдгээр нүхнээс гарсан шороо, хайрганы зарим хэсэг нь тэндээ овоолж орхисон, зарим хэсгийн чулууг буталж тээрэмдэн алт олборлосон байж болзошгүй байдал ажиглагдаж байв. Нөхөн сэргээлт хийгдээгүй. Уурхайчдын байр нь хүний амьдрах наад захын шаардлага хангахгүй, хүйтэн, харанхуй, цементэн төмөр бетон шалтай байна. Ашиглалтын зөвшөөрлөө хөөцөлдөж байгаа үйл ажиллагаа явуулаагүй гэдэг боловч 2007.12.12-нд хийсэн шалгалтаар тэндээ усан тээрэм байрлуулж хууль бусаар химийн хорт бодис ашиглаж алт бариулж байсан тухай мэдээлэл байсан тул дээж авч геологийн төв лабораторид мөнгөн ус мөн эсэхийг тогтоолгохоор шинжилгээнд явуулж, тоног төхөөрөмжүүдийг нь лацадсан байна.

Биднийг АШБ ХХК-ийн хайгуулын газар 2008.01.21-ний өдрийн 17.00 цагийн үед очиход өгөөмөр security гэх хамгаалалтын албаны 5 залуу харуулаар, нэг тогоочтой байсан. Хамгаалалтын албаны дарга Г.Сүхбаатар. 4 том нохойтой. Заамар сумын байгаль хамгаалагчийн ярьснаар өмнө нь нэг удаа нохой нь алдуурч нохойд нь хазуулж байсан гэв. Ажилчдын байр, шүрүүнд, уурхайг нүхэлсэн байдалтай танилцсаны дараа 4 монгол залууг тэнд хорьж байгаа гэсэн мэдээллийг олов. Тэдгээр иргэдтэй уулзуулахгүй гэсэн уурхайн хамгаалагчдад өөрсдийн зорилго, байгууллагын эрх үүргийг танилцуулж байж орж уулзав. Хоригдож байсан 4 залууг Адарсүрэн, Ганзориг, Нямдаваа, Одсүрэн гэдэг бөгөөд өмнөх шөнө нь алт ухахаар орох гэсэн гэнэ. Хамгаалалтын албаны залуучуудад мөнгө өгч орох гэсэн боловч оруулахгүй гэсэн, тэгэхээр нь бид буцаад явж байтал араас нохойтойгоо хөөж ирсэн. Бид нохойд нь уруулчих болов уу гэж айгаад зугтаагүй. Тэгтэл биднийг авч ирээд гадаа хүйтэн төмрөөс 2 цаг гавлаж зогсоосон. Дараа нь 5 цагийн үед хүн амьдрахын аргагүй байранд оруулж байлгасан. Бид гал гуйсан боловч өгөөгүй. 7 цагийн үед нэг жаахан мод өгсөн. Тэгээд та нарыг ирсэн сургаар бид нарыг дулаахан өрөөнд оруулж гал түлж, аяга цай өгөөд л байж байна гэсэн юм. Хамгаалалтын албаны даргаас энэ тухай тодруулахад эд нар бол нинжа, байнга ингэж ирдэг юм. Тэгээд бид хэсгийн төлөөлөгч Дэлгэрбаяртай холбогдож тэднийг яах тухай асуухад би аймаг дээр явж байна. Наанаа байлгаж бай би маргааш очоод авна гэсэн гэв. Энэ тухай шаардлагатай бичлэгүүдийг хийсэн болно.

- Бат алт төв ХХК нь Баянголын дэнжид 1668А лицензийн дугаар бүхий 55.2 га талбайд 1998 оноос хойш үйл ажиллагаа явуулж байна. Эвдэгдсэн нийт талбай нь 55.2 га бөгөөд үүнээс 46.1 га-д нөхөн сэргээлт хийсэн.

- Зэрэгцээ ХХК-ийн нийт талбай нь 836 га бөгөөд 215 га-д олборлолт явуулж 98 га-д нөхөн сэргээлт хийсэн байна. 7137А, 7197А, 10875А лицензийн дугаартай 2004 оноос хойш үйл ажиллагаа явуулж байгаа.

- Илгуан ХХК-ийн нийт хөндөгдсөн талбай нь 14 га бөгөөд 6 га-д нөхөн сэргээлт хийсэн байна. Солонгос эзэнтэй бөгөөд эзэн нь техникээ зараад нутаг буцсан.

- Оргил мөнх ХХК туулын баруун дэнжид 5640А лицензийн дугаар бүхий 7.9 га газар олборлолт явуулж байна. Хөндөгдсөн нийт талбай нь 7.9 га бөгөөд нөхөн сэргээлт хийгдээгүй байна.

- Тэмүүлэл, Т энд Ч ХХК-ууд нөхөн сэргээлтийг огт хийгээгүй байна.

- Эрэл ХХК-нь Баянголын дэнж дээр 1997 оноос хойш 206А лицензтэйгээр 41 га талбайд олборлолт явуулж эхэлсэн бөгөөд нөхөн сэргээлт огт хийгээгүй байна. Лицензнийхээ тал газрыг Алтан Дорнод Монгол ХХК-д заржээ. Уг баянголын дэнж дээр 41 га талбайд 20-оод метр гүн 3 карьер, 2 овоолго нөхөн сэргээлгүй орхиж үйл ажиллагаагаа зогсоогоод 6 жил болж байна.

Алтан Дорнод Монгол ХХК-ийн нинжа нараас хамгаалах нэрийдлээр ухсан зогоон нь 1.5-2 метрийн өргөнтэй 2 метрийн гүнтэй урт нүх байна. Зогооныг татсанаар нутгийн малчид малаа услахын тулд маш их тойрдог, зогоон татсанаас газрын хөрс эвдэрдэг зэрэг сөрөг үзэгдлүүд ихээхэн гарч байна. Алтан дорнод монгол ХХК нь зогоон татаж иргэдийг орж гарах болгонд шалгадаг. Бичиг баримтгүй бол торгоно гэх зэргээр нутгийн иргэдэд хүндрэл учруулдаг бөгөөд үүнийгээ тэд нинжа нараас хамгаалж байна гэж тайлбарладаг аж.

Нутгийн иргэдийн ярьж буйгаар нинжа нарын ухсан нүхэнд мал их орж үхдэг, заримдаа морьтой хүн унадаг тохиолдол ч байдаг гэж байлаа. Өнгөрсөн намар гэхэд 1 үнээ, 1 гуна унаж үхсэн байна. Нинжа нар алт олборлох явцдаа голын усанд алтаа угаах, уулнаас мод авч түлшиндээ хэрэглэдэг зэрэг нь байгаль орчинд сөргөөр нөлөөлж байна. Заамар суманд нийт 8-10 мянган нинжа гар аргаар алт олборлож байсан бөгөөд сумын засаг даргын тамгын газар, цагдаагийн байгууллага, алтны уурхайнууд хамтран эдгээр гар аргаар алт олборлогчдыг тараасан байна. Өмнө нь сумын нутаг дэвсгэрт байрлах ус цаг уурын шинжилгээний газраас мөнгөн ус их алддаг байсан байна.

Өмнө нь эцэг нь заамарт хууль бусаар алт олборлож байгаад зүүнхараад очиж хууль бусаар алт олборлож байгаад нас барсан явдал гарсан байна. Түүнийг Заамар сумын иргэд мөнгө нийлүүлэн оршуулж, хүүхдийг нь харж хамгаалж байна. Хүү одоогоор Заамар сумын 11 жилийн сургуулийн 9-р ангид сурч байгаа. Саяхан бичиг баримтыг нь авч өгсөн байна.

Одоогийн ашигт малтмалын хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа явуулж байгаа компаниудаас "АШБ" ХХК-аас бусад нь үндсэндээ Хайлааст 3-р багийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаагаа явуулж байгаа юм байна.

3-р багийн нийт хүн ам 3169 буюу сумын хүн амын 54.5 хувийг, 890 өрхтэй буюу сумын айл өрхийн 54.4 хувийг тус тус эзэлдэг байна. Харин 19315 малтай 81 өрх байдаг боловч мал бэлчээх бэлчээргүй шахам болсон, ялангуяа малчид зуслан, хаваржаа, намаржаагүй болсон байна. Ашигт малтмалын үйл ажиллагааны улмаас Туулын голоос гадна 4 гол байгаагийн Баянгол, Хайлааст, Цагаан булаг зэрэг 3 голын ундарга багассан, наймганы гол үндсэндээ ширгэсэн байна. Иймээс малчид малаа туул голоос услах зайлшгүй шаардлагатай болдог хэдий ч гол руу явах замыг нь хааж 180-200 см өндөр, 150-180 см өргөн суваг татаж, зарим хэсэгт нь уурхайн олборлолт явагдаж 30-40 метр гүн, 10-25 метр өндөр овоолго гаргаж хүн мал явах аргагүй болсон, ганцхан өгөөмөр гэдэг газраар мал явах гарцтай юм байна. Үүнээс болж малчид малаа услахад маш хүндрэлтэй болжээ. Малчидтай уулзахад малчин М.Удаанжаргал, Лхагва нарын хэсэг малчид уурхайнхан туулын голыг бохирлож байна.

Голоос авсан ус шаварлаг шар тунадастай булингартсан, хүний ундны хэрэгцээнд тохирохгүй байж болшгүй байдал анхаарал татаж байна. Энэ нь ашиглалт явуулж байгаа зарим компаниуд алт угаасан усаа технологийн дагуу цэвэрлэхгүй туул гол руу урсгаж байгаатай холбоотой юм. Үүнээс гадна "Шижир Алт" ХК нь Туулын голын гольдрилыг өөрчлөн усыг урсгаж, гольдрол дотор хоёр том драгаа ажиллуулдаг. Харин Алтан Дорнод Монгол компани нэг, Монполимет ХХК хоёр драг туулын голоос ус татан хиймэл нуур үүсгэн ажиллуулдаг байна.

Энэ бүхнээс шалтгаалан Туулын гол багасч, бохирдож байгаа нь цаашид ширгэх аюулд хүрэхийг үгүйсгэхийн аргагүй юм. Уурхайн нөхөн сэргээлт бараг хийгддэггүй байсаар 2006 оноос бага зэрэг хийгдэж, 2007 онд Улсын мэргэжлийн хяналтын газар, Заамар сумын удирдлагатай хамтран нөхөн сэргээлтийн үзүүлэх сургууль зохион байгуулж, энэ арга хэмжээгээ угтан уурхайн компаниудаар нөхөн сэргээлтийг маш эрчимтэй хийлгэж, энэхүү үзүүлэх сургуульд уул уурхайн ихэнхи компаниудыг оролцуулсан нь маш чухал ач холбогдолтой болжээ.

Энэ багийн нутагт үйл ажиллагаа явуулдаг компаниудаас Монполимет, Дацан трейд хоёр компани бусдыгаа манлайлан техникийн болон биологийн нөхөн сэргээлтийг

11

сайн хийж түүний дараа “Алтан Дорнод Монгол” ОХУ-ын 100 хувийн хөрөнгө оруулалттай компани нөхөн сэргээлт хийсэн байна.

“Монполимет” ХХК нь нөхөн сэргээлт хийсэн газраа төрөл бүрийн жимсний мод, 5000 цаггаагулиас, олон наст ургамал хүнсний ногоо хүртэл тарьжээ. Энэ 3-р багийн төв нь өгөөмөр тосгон бөгөөд энэ тосгонд нийтдээ 800 гаруй өрх амьдардаг өвлийн цасан бүрхүүлтэй үеэс бусад улиралд байнгын тоосонцортой салхи ихтэй үед явган хүн хоорондоо мөргөлдөх шахам үзэгдэлт байхгүй болдог гэж багийн засаг дарга Л.Гансүх болон бусад хүмүүс ярьж, энд оршин суугчдын эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх байнга зөрчигдөж байгааг төр, засаг анхааралдаа авах цаг болсныг онцлон сануулж ярьж байв. Мөн алт олборлох зорилгоор 30-40 метр ухсан газрын гүнээс элдэв хортой хий гарч болзошгүй хэмээн үзэж байдгаа илэрхийлэн ярьж байв. Байдлыг газар дээр нь явж үзэхэд өгөөмөр тосгоны орчмын газар бүрэн эвдэрч, талхлагдаж эрүүл газаргүй болсон байна.

Бид дээр дурдсан 20 гаруй уурхайн ашиглалт явагдаж эвдэрч ухсан, шороон овоолго хийсэн газруудаар нэг бүрчлэн явж үзэхэд нөхөн сэргээлт хийгдсэн хэдэн “га” газраас бусад бүх газрууд үндсэндээ 10-40 метр орчим гүн ухсан, 10-30 метр өндөр овоолго, гадуур нь 2 метр шахам гүнзгий ухсан суваг шуудуу /зогоон/ хүн мал явах аргагүй болсон газар байлаа. Үүнээс болж энэ багийн 80 гаруй малчин өрхийн 19.3 мянган толгой мал, уул хаднаас өөр бэлчээрлэх газаргүй, малчид нь хадлан авах газаргүй, төр засгийн зүгээс зохицуулалт хийхгүйгээр тэдгээр өрх айлууд хэвийн оршин амьдрах боломжгүй болж байгаа нь мэдрэгдэж байлаа. Ялангуяа тосгоны зүүн урд ар наймганы 21 малчин өрхийн өвөлжөө, хавар, намар байнга оршин амьдардаг нутаг газрыг ашиглалтын лицензээр “Алтан Дорнод Монгол” компанид олгосны улмаас тус компани, нутгийн иргэдийн хооронд маргаан үүссэнийг багийн засаг дарга Л.Гансүх малчидтайгаа зохицоод дээрхи компанитай тохиролцвол энэ компанийн зардлаар тэдгээр айлуудыг өөр нутагт шилжүүлэн суурьшуулах боломжтой байгаагаа танилцуулсан юм.

Танилцах судалгааны явцад хийж гүйцэтгэсэн бусад ажлууд

1. Сумын ИТХ, Засаг даргын тамгын газрын болон соёл, боловсрол, эмнэлэгт хувийн хэвшлийн ба төрийн бус байгууллагын ажилтан, сонгуультаан 20 гаруй хүнд олон нийтийн эрх ашгийг хамгаалах, эрүүл аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхийг хангах талаар тавигдаж буй шаардлагын талаар мэдээлэл хийж, харилцан ярилцаж, тэдний саналыг сонсов.

Тус заамар суманд гар аргаар алт олборлогч ямар ч зохион байгуулалтгүй, ухсан газраа эргэн булахгүй орхидог, өөрсдөө шороонд дарагдаж үхдэг, хулгай, дээрэм, танхай, архидалт хавтгайрсан, хүний эрх зөрчих явдал наад захын асуудал байсан учир нинжа-г хөөж явуулсан нь зүйтэй арга хэмжээ болсон. Химийн хорт бодис хэрэглэдэг явдлыг ХЭҮК-оос онцгой анхаарч тэмцэх нь зүйтэй, нөхөн сэргээлтийг хийлгэх асуудалд төрийн бодлого үндсэндээ алдагдсан гэж үздэг. АШБ ХХК ажиллагсадаа шоронгоос доор байранд байлгадаг, Алтан Дорнод Монгол ХХК хүний эрх их зөрчдөг. Заамар суманд ийнхүү цаашид ашигт малтмалын үйл ажиллагаа явуулбал Туул гол ширгэж, тэр орчинд цөлжилт явагдаж болзошгүй гэж үздэг учир ХЭҮК-оос нарийвчилсан судалгаа шинжилгээ хийлгэж өгөхийг санал болгож байна. Хоцрогдсон техник, технологиор алт олборлож байгаа нь нөхөн сэргээлт хийгээгүйтэй шууд холбоотой. Учир нь ухсан газраа дахин ашиглана гэж орхидог тал бий. Улсын байцаагч уурхайг хаагаад явахад зөрчил, дутагдал засагдаагүй байхад тэр дороо л нээгээд ажиллуулдаг. Нөхөн сэргээлтийг төрийн зүгээс зохицуулалт хийхгүйгээр үр дүнд хүрэхгүй болсон. Алтан Дорнод Монгол зэрэг зарим уурхайн хамгаалалтынхан нинжаг оруулахгүй гэдэг нэрээр нутгийн иргэдийг

нааш цааш явуулахгүй шалгадаг гэх мэтээр үзэл бодол, саналаа 9 хүн илэрхийлж гаргав.

2. Тус сумын төвийн 4-р багийн нийтийн хуралд оролцож, дээрхи сэдвээр мэдээлэл хийж иргэдийн асуудтад хариулав. Дээрхийн нэгэн адил сумын иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах эрх зөрчигдөж байгааг шүүмжлэн ярьж байв. Энэ хуралд 60 гаруй хүн оролцов.

3. Өгөөмөр тосгонд 3-р багийн нийтийн хуралд оролцон товч мэдээлэл хийлээ. Уурхайн компаниуд нөхөн сэргээлт хийхгүй байгааг, Туул гол руу бохир усаа урсгаж байгаа, малчдын бэлчээр, оршин суурьших газаргүй болгож байгаа, нутгийн иргэдийн саналыг авахгүйгээр хамаагүй дураараа лиценз олгож байгаа зэрэг асуудлыг шүүмжлэн ярьж байлаа. Энэ хуралд 120 гаруй иргэд оролцлоо.

4. Танилцах судалгааны бүх явцад онцлог үйл явдлуудын зургийг видео бичлэгээр авсны зэрэгцээ телевизийн нэвтрүүлэгт зориулж сэтгүүлч Ш.Мөнхцэцэг, зураглаач Д.Энхтөр нар ярилцлага, зураг авалтыг хийсэн болно.

Энэ судалгааны явцад дээр дурьдсанаас гадна ашиглалтын тусгай зөвшөөрөл олгохдоо орон нутгийн нөхцөл байдал, эрх ашгийг хэрхэн хөндөгдөхийг үл хайхардаг байсны бас нэг баримт гэвэл: 2002 онд Кадасртын алба өгөөмөр тосгоны ихэнхи айл өрх оршин суугаа газарт 411 тоот лицензээр ашиглалт явуулах тусгай зөвшөөрөл олгосныг нутгийн захиргаа, иргэд нилээд тэмцэл хийсний үр дүнд тусгай зөвшөөрлийг цуцлуулсан байна. Хэрэв лицензийг цуцлуулаагүй бол 600 гаруй айл өрх газарт орж нүүлгэн шилжүүлэх шаардлага гарч маш их чирэгдэл учруулах байжээ.

Тэрчлэн ашиглалт явуулаад нөхөн сэргээлт хийгээгүй зарим компани нэрээ өөрчлөөд дахин өөр газарт ашиглалтын тусгай зөвшөөрөл авсан явдал гарч байна. Энэ талаар “Т энд Ч” ХХК-д ингэж тусгай зөвшөөрөл олгосныг дээр өгүүлсэн билээ. Тусгай зөвшөөрлийг шилжүүлэхдээ орон нутагт огт мэдэгддэггүй. Нэг л мэдэхэд өөр компанид шилжүүлсэн байдаг гэж сум, багийн засаг дарга нар гомдол мэдүүлж байв. “Эрэл” ХХК нь 41 га талбайд олборлолт явуулж 3 том овоолго, нилээд хэмжээний том ухсан нүхнүүд үлдээгээд ямарч нөхөн нөхөн сэргээлт хийлгүйгээр орхиход явсан 5-6 жил болж байгаа тухай дээр дурьдсан билээ. Сүүлийн үед зарим газраа “Алтан Дорнод Монгол” ХХК-д шилжүүлсэн сураг дуулдсан гэж тайлбарлаж байлаа.

2008 оны 1 дүгээр сарын 24-ны өдөр Төв аймгийн Жаргалант суманд хагас өдөр ажиллав. Хүнс хөдөө аж ахуйн яамнаас төлөөлөгчид жаргалант суманд хүрэлцэн ирж нутгийн иргэдтэй уулзалт хийж байсан юм. “Жаргалант нутгаа аваръя” хөдөлгөөний тэргүүн Ц.Баасандорж тэргүүтэй 5 хүнтэй уулзаж, ярилцаж холбогдох баримт бичгийг үзэж танилцав. Тус Жаргалант сумын Баянбулагийн гуравдугаар багийн Нарантолгой хэмээх газарт Хятадын 100 хувийн хөрөнгө оруулалттай “Тэн Хун” гэгч компани өнгөрсөн оноос эхлэн алт олборлох үйл ажиллагаагаа эхэлсэн, уулын энгэрийг ашиглалтын талбай болгосон байна. Энэ уурхай нь үндсэн орд бөгөөд ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг 2007.01.23-нд авсан, тусгай зөвшөөрлийн дугаар 713А, “Нарантолгой” хэмээх газарт ашигт малтмал ашиглахыг зөвшөөрч 9019016020-рт бүртгэж, Ашигт малтмал газрын тосны хэрэг эрхлэх газрын нэгдүгээр орлогч Ц.Ганхуягийн гарын үсэгтэй гэрчилгээ олгожээ. Мөн байгаль орчны яамны хүрээлэн буй орчин байгалийн нөөцийн газрын дарга ХХБАББЗАЭҮЗ-ийн шинжээчийн багийн ахлагч Ц.Банзрагч, зөвлөлийн нарийн бичгийн дарга Л.Жаргалсайхан нарын гарын үсэгтэй химийн хорт бодис болон аюултай бодис экспортлох, импортлох, хил дамнуулан тээвэрлэх, үйлдвэрлэх, ашиглах, худалдаалах, устгах /0000141/, 2007/167 дугаар бүхий зөвшөөрлөөр “Тэн Хун” ХХК-д туршилтын журмаар натрийн цианид 25 тонн, давсны хүчил 18тонн, Азотын хүчил 18 тонн, Хүхрийн хүчил 18 тонныг тус тус зөвшөөрч, зөвшөөрлийн хугацаа 2007 оны 10-р сарын 29-оос 2008 оны 10-р сарын 28-нд нэг

жилийн хугацаатай Замын үүд боомтоор оруулахыг зөвшөөрч гэрчилгээ олгосон, уг химийн бодисуудыг оруулж ирсэн эсэх нь одоогоор мэдэгдээгүй байна.

Нарантолгой хэмээх уул нь сумын төвөөс 5 км зайтай, зүүн хойд талд, багийн төвөөс 3 км зайтай, энэ уулын хажууд гол төлөв төмс, хүнсний ногоо тарьдаг.

Жаргалант сум, түүний дотор энэ уулын 3 талд газар тариалан, хүнсний ногоо тариалдаг гол газар бөгөөд Монгол улсын газар тариалангийн бүс нутаг юм. Жаргалант суманд гэхэд өнгөрсөн онд 5137 га-аад 2070 тонн үр тариа, 11193 тонн төмс, хүнсний ногоо тариалжээ. Жаргалант сум нь Төв аймгийн хэмжээний төмс, хүнсний ногооны 40 гаруй, улаан буудайн тариалангийн 30 гаруй хувийг тарьдаг гэсэн тооцоо байдаг байна.

“ТэнХун” ХХК нь алт олборлохдоо “Талын булаг” гэдэг голын усны ай сав, хагалбар газрын усыг татаж хэрэглэх учир энэ бүс нутагт ундны усгүй болгож болзошгүй байдалд хүргэх юм байна. Энэ компанид ашиглалтын тусгай зөвшөөрөл олгохдоо Монгол улсын газар тариалан, төмс хүнсний ногоо тариалах тариалангийн бүс нутаг сумын төвд ойрхон, үндсэн ордтой, химийн хорт бодис зайлшгүй хэрэглэх нь ойлгомжтой байхад орон нутгийн зөвшөөрөл авалгүй, нутгийн иргэдээр хэлэлцүүлэг явуулахгүйгээр шийдвэрлэсэн нь хариуцлагагүй хандсан асуудал юм. Байгаль орчны яам ч туршилтын журмаар хэрэглэнэ гэсэн байхад ийм их хэмжээний химийн бодис зөвшөөрсөн нь энэ бүс нутагт аюул учруулах алхам хийсэн хариуцлагагүйн илрэл юм. Эдгээр тусгай зөвшөөрлийг цаашид хүчингүй болгуулах нь зүйтэй гэж үзэж байна.

Төв аймгийн Борнуур суманд энэ сарын 24-25нд ажиллаа. Сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн дарга Н.Өлзий, байгаль орчны хяналтын улсын байцаагч М.Мөнгөнчимэг, хууль зүйн ажилтан Ч.Хишигтогтох, цагдаагийн хэсгийн төлөөлөгч а/х М.Уламбаярлах нартай уулзаж, удирдамжийн дагуу зарим зүйлийг асууж, холбогдох баримт бичгийг үзэж танилцав.

Энэ суманд алтны хайгуулын тусгай зөвшөөрөлтэй 15, ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй 3 компани ажилладаг юм байна. Үүнээс Сэндрогоулд, Гүнбилэгт, Бреивхарт зэрэг 3 компани нь ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй, үйл ажиллагаагаа дөнгөж эхэлж буй тул нөхөн сэргээлт хийх болоогүй юм байна. Харин нутгийн иргэд Сүжигт ууланд гар аргаар алт олборлох ажил эрхэлдэг. Дунджаар 200-250 хүн ирэн, очин ажилладаг байжээ. Тэдгээрээс аюулгүй байдлыг хангахгүй ажилласнаас нуралт үүсч шороонд дарагдан амь насаа алдах, гэмтэх, архидаг согтуурч биенийхээ амь нас, эрүүл мэндэд халдах явдал урьд жилүүдэд гарч байсан, харин 2007 онд нэг л хүн амины хэрэг гарснаас биш тэсэрч дэлбэрэх бодис хэрэглэснээс болж хүний амь нас, эрүүл мэндэд хохирол учруулаагүй. Хэвлэлээр худал мэдээлэл нийтэлсэн гэж хэд хэдэн хүн тайлбарлаж байлаа. Тэдгээр хувиараа гар аргаар алт олборлогчид 2007 оноос зохион байгуулалтанд орж, бичил уурхай эзэмшигчид болж байгаа гэж байв. Харин сумын төвөөс хойш 10 гаруй км-т “Ананд интернэйшнл” компани “гүйцэтгэх захирал нь Ганболд, менежер нь Н.Шинэтуяа нар/ нь шлам, алтны илэрц бүхий шороо зөөж, газар ухаж химийн бодис хэрэглэж алт бариулах ажил эрхэлж 2006-2007 онд үйл ажиллагаагаа явуулсан боловч тусгай зөвшөөрөл байхгүй, уг химийн бодисыг нэрлэж мэдэхгүй, 3-4 хятад мэргэжилтэн нэртэй хүмүүс авчирч ажиллуулсан бөгөөд химийн бодистой усаа газар ухаж целфон цаасаар жийрэглэн ил задгай хадгалж байсныг шинжилгээ хийлгэхээр үзэхэд цианит байсан нь тогтоогдож, Төв аймгийн цагдаагийн газрын мөрдөн байцаах тасаг эрүүгийн хэрэг үүсгэн шалгаж байгаа юм байна.

Энэ талаар УИХ-ын гишүүн Н.Энхболд Улсын мэргэжлийн хяналтын асуудал эрхэлсэн сайд асан У.Хүрэлсүхэд асуулга тавихад хариуд нь ийнхүү мэдэгдсэн байна.

Засгийн гарын 2006 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн ЗГ 3/825 тоот бичгээр хариу мэдэгдэхдээ уг бичигт: Борнуур сумын нутагт “Ананд Интернэйшнл” ХХК алт олборлох үйлдвэрт онцгой хортой химийн бодис цианит натрийг хэрэглэсэн эсэхийг үйлдвэрийн талбайд уусгалт хийгээд булж орхисон нүхнээс шлам шар ус, бохир усны дээжийг авч Геоэкологийн хүрээлэнгийн усны шинжилгээний лаборатори, геологийн төв

лабораторид өгч шинжлүүлэхэд ...энэ компани нь алт олборлох үйл ажиллагаатай холбогдсон баримт бичиг болон зөвшөөрөлгүйгээр онцгой хортой химийн бодис цианит натри ашигласан үйл ажиллагаа явуулсан нь шинжилгээний дүнгээр тогтоогдсоноос гадна улсын байцаагчдын тавьсан шаардлагыг удаа дараа зөрчин 0.35 га газрыг онцгой хортой химийн бодисоор бохирдуулан орхиж явсан тул холбогдох материалыг бүрдүүлэн Цагдаагийн Ерөнхий Газрын Мөрдөн байцаах газарт эрүүгийн хэрэг үүсгүүлэхээр шиллжүүлсэн... гэжээ. Энэ бодисыг оруулсан буюу хэрэглэсэн хятадууд нь буцаад явснаас хэрэг шийдвэрлэгдэхгүй хүлээгдэж байгаа юм байна.

Зөвшөөрөлтэй 3 компани химийн бодис хэрэглээгүй бөгөөд "Гүнбилэгт" ХХК сумын төвөөс 10 гаруй км зайтай Харганат ууланд, "Сэндрогоулд" ХХК нь сүжигт ууланд сумын төвөөс зүүн хойш 30 гаруй км зайтай, "Бреивхарт" ХХК нь сумын төвөөс 10 гаруй км зайтай Баянцагаанд тус тус үйл ажиллагаа явуулдаг юм байна. 800 үнээний фирмийн ойролцоо хувиараа алт олборлогчид мөнгөн ус болон химийн хорт бодис хэрэглэж байсныг аймгийн мэргэжлийн хяналтын байцаагч нар 4-5 тээрэм байсныг хураасан байна. Энэ үйл ажиллагаа нь зохих техник, технологийн дагуу явагддаггүй учир хүн, амьтны эрүүл мэнд, байгаль орчинд хохирол учруулж болзошгүй байдалтай байжээ.

Дүгнэлт хийх нь:

1. Заамар суманд уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа болон хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа явуулсан аж ахуйн нэгж байгууллагууд 2006 оноос өмнө нөхөн сэргээлт хийдэггүй байсан. Үүний улмаас нөхөн сэргээлт огт хийгээгүй найман компани, хагас хийсэн буюу нөхөн сэргээлт дөнгөж эхлэлтийн байдалтай байгаа дөрвөн компаниуд байна.

Заамар сумын засаг дарга, Байгаль орчны хяналтын улсын байцаагчийн зүгээс хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхийг хангах талаар зохион байгуулсан ажлын зарим талын үр дүн байгаа боловч энэ талаар тооцоо судалгаа муутай, хэт ерөнхий хандсан тал ажиглагдаж байна. Сумын иргэдийн төлөөлөгчдийн хурал, түүний тэргүүлэгчид санаачлагатай ажиллаж байгаа юм байна.

Энэ суманд ашигт малтмалын үйл ажиллагааг үргэлжлүүлэн явуулах бол байгаль орчны нарийвчилсан үнэлгээг хайгуул, олборлолт явагдаж буй газруудад хийж, БОЯ-ны зүгээс хянан магадлагаа хийх иж бүрэн судалгаа, шинжилгээ хийж дүгнэлт гаргуулах, нөхөн сэргээх ажлыг улс хяналтандаа авч ажиллах шаардлагатай гэж үзэж байна.

2. Газар тариалан, төмс хүнсний ногоо тариалах бүс нутаг болох Жаргалант, Борнуур сумдын нутагт үндсэн орд ашиглах, химийн хорт бодис хэрэглэх явдлыг нэг хэсэг хугацаанд хориглож, энэ талаар байгаль орчны талөв байдлын нарийвчилсан үнэлгээ болон хянан магадлагааг дахин хийлгэх арга хэмжээ авах

3. Судалгааны явцад илэрсэн зөрчил, доголдлыг арилгахтай холбоотой асуудлаар шаардлага, зөвлөмж холбогдох газарт явуулах,

4. Телевизийн нэтрүүлгийг явуулах ба хүний эрх, эрх чөлөөний илтгэлд зарим тулгамдсан асуудлыг тусгах

Танилцах судалгаа хийж, илтгэх хуудас бичсэн
ХЭҮК-ын төслийн үндэсний зөвлөх *Г. Далайжамц* /Г. Далайжамц/
Комиссын референт *Б. Долгион* /Б. Долгион/